



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

“ТТСЕК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.3, “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 14.1.1, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 34.1.4 дэх заалт болон Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “ТТСЕК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “ТТСЕК” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, баримт хүлээлцэх ажлыг зохион байгуулж, арилжаа эрхлэх, төлбөр тооцоо хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын төлөөлөл бүхий комисс томилон ажиллуулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компанийн хэлцлийн жагсаалтыг үндэслэн харилцагчийн үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой баримтыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/, арилжаа болон санхүүгийн баримтыг “Монголын хөрөнгийн бирж” ХХК /Х.Алтай/-иудад өөрийн байгууллагын архивт хүлээн авахыг тус тус үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсонтой холбогдуулан харилцагчийн арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн баримтыг “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 9.3-д заасны дагуу цэгцлэн архивын нэгж болгон арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо хадгаламжийн байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг “ТТСЕК” ХХК /Ц.Бүрэнжаргал/-д үүрэг болгосугай.

5. Тус компанийн харилцагчдыг брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бусад компанид шилжүүлэх асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харъяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээллэж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

